БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МЯГМАР

# ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# “ОРОН НУТГИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТЕЛЕ КАМЕРЫН СИСТЕМ (БОСОО ТЭНХЛЭГ)” НЭВТРҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БАЙРШУУЛАХ ШОНГИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

**БАГЦ1.ХЗДХЯ/20240102008001**

Улаанбаатар хот
2024 он

**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БАЙРШУУЛАХ ШОНГИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

| | | |
|---|---|---|
| 1 | Байршил | Улаанбаатар хотоос Гашуунсухайт боомт хүртэлх А0201, А0202, Замын-Үүд боомтоос Алтанбулаг боомт хүртэлх А0101, А0102, А0103, А0401, А0402, А0403 дугаартай автозам |
| 2 | Захиалагч байгууллага | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br>Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба |
| 3 | Зураг төсөл боловсруулах байгууллага | Төсөл боловсруулах<br>байгууллага нь тухайн чиглэлийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, ажлын туршлагатай байна. |
| 4 | Зураг төсөл боловсруулах ажлын үе шат | - Нэг үе шаттай /Ажлын зураг, төсөв/ |
| 5 | Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал | Хяналтын камер суурилуулах төмөр шонгийн зураг боловсруулах. Үүнд<br>- Г хэлбэртэй төмөр шон. Авто замын хучилтаас дээш 8м, гарны урт 6м<br>- П хэлбэртэй төмөр шон. Авто замын хучилтаас дээш 8м, зорчих хэсгийн өргөн урт 9м<br>- П хэлбэртэй төмөр шон. Авто замын хучилтаас дээш 8м, зорчих хэсгийн өргөн 21м<br>Шаардлагатай нөхцөлд тухайн байршилд тохируулан хэмжээг өөрчлөх боломжтойгоор төлөвлөх |
| 6 | Барилгын үндсэн бүтээц, материал | Төмөр /металл/ бүтээц |
| 7 | Зураг төсөл боловсруулах ажил эхлэх, дуусах хугацаа | - Гэрээт хугацаа |
| 8 | Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | - Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, норм ба дүрэм, журам, стандартууд<br>- Тээврийн цагдаагийн албаны санал, зөвлөмж, шаардлага<br>- Олон улсад ашиглаж байгаа шинэ, дэвшилтэт техник, технологи |
| 9 | Зураг төсөл боловсруулахад | Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд: |

| | | |
|---|---|---|
| | шаардлагатай баримт бичгүүд | - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад хэрэглэх хууль, тогтоомжууд<br>Монгол Улсын барилгын норм, дүрмийн хүрээнд:<br>- Барилгын самбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив баримт бичгүүд. |
| 10 | Баримт бичгийн бүрдэл | Бичиглэлийн иж бүрдэл:<br>- Зураг төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбилцолын нэгдсэн системд хийж гүйцэтгэх, батлагдсан ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, инженерийн шугам сүлжээ, нэгдсэн төсөвт өртгийн тооцоо болон магадлалын ерөнхий дүгнэлт бусад холбогдох бичиг баримтыг /иж бүрэн зураг төсөл/ захиалагчид хүлээлгэн өгөх. /Эх хувь-1%, Хуулбар-2% өнгөтөөр/, /3Ds, dwg, skp, pdf, est, jpeg doc, xls өргөтгөлөөр/ |
| 11 | Зураг төсөлд тавигдах шаардлага | - Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт;<br>- Хот байгуулалтын тухай хуулийн 12.5, 12.6, 12.8, 20.2 дахь заалт;<br>- Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2-д заасан шаардлагыг хангасан байх;<br>- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг бүрэн дарж, магадлалаар баталгаажуулсан байх;<br>- Түүх соёлын үнэт өв дурсгал замын трасст орсон тохиолдолд холбогдох байгууллагуудтай зөвшилцөн хамгаалах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлэсэн байна.<br>Монгол Улсын байгаль, цаг уурын онцлог, тооцооны үндсэн өгөгдөл, хууль тогтоомж, норм дүрэм стандартыг баримтлан ажлын зураг, төсвийг боловсруулах. Төсвийг тооцооны ESTIMATOR-PRO программ/-аар гүйцэтгэх |
| 12 | Зөвшөөрөлцөх байгууллага | - Хууль зүй, дотоод хэргийн яам, Тээврийн цагдаагийн алба<br>- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-д заасан холбогдох байгууллагууд |

---o0o---